ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 14 өдөр Дугаар А/28 Сүмбэр сум

Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/33 дугаар тушаалаар батлагдсан "Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журам"-ын 8 дугаар зүйлийн 8.2.4 Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/29 дугаар тушаалаар батлагдсан "Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1, 3.3 тус тус ТУШААХ нь:

1. Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд өмгөөллийн үйлчилгээнд холбон зуучилж ажиллахыг Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Ч.Анхтуяа)-д даалгасугай.

2. Өмгөөллийн үйл ажиллагааны зардал 700.000 (долоон зуун мянга) төгрөгийг гэрээнд заагдсан хугацаанд бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг нягтлан бодогч (Д. Оюунцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Ц.ОЮУНБИЛЭГ

D:/Бичиг хэрэг /тушаал